					<p>арга хэмжээ авч, эрх бүхий албан тушаалтны албан даалгавар хүргүүллээ. Мөн урьдчилан цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын үйл ажиллагааг эрчимжүүлэх хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс бохирдуулагч үйлдвэрүүдэд Нийслэлийн Хяналт шалгалтын газраас Барилга байгууламжийн техникийн хяналтын Улсын ахлах байцаагчийн 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 02-13-02/041/321-358 хүртэл дугаартай албан шаардлагыг 37 аж ахуйн нэгжид хүргүүлсэн.</p> <p>Нийслэлийн Засаг дарга бохирдуулагч үйлдвэрүүдийн удирдлагуудтай 2025 оны 08 дугаар сарын 19-ний өдөр уулзалт хийж урьдчилан цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулах талаар мэдэгдэл хийж, Аж ахуйн нэгж бүр Нийслэлийн Засаг даргын тамгын газар болон Ус сувгийн удирдах газартай урьдчилан цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулах хугацаатай гэрээ байгуулахыг үүрэг болгосноор албан шаардлагын биелэлтийг хангагдах ажлын нэг хэсэг болсон.</p> <p>Мөн Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамны төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/153 дугаартай Ажлын хэсэг байгуулах тухай тушаалын дагуу гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хэрэгжүүлж байна.</p>		
Зорилт-3: Хяналт шалгалтын цахим системийг нэвтрүүлж, шаардлагатай мэдээллийн хүртээмж, ил тод байдлыг хангана. /МУЗГҮАХ-4.1.4.1, НЗДҮАХ-5.1.8/							
2	Арга хэмжээ 1.1 Хяналт шалгалтын нэгдсэн цахим систем буюу application хөгжүүлэлтийн ажилд дэмжлэг үзүүлж, хяналт шалгалтад нэвтрүүлж ажиллана.	Хяналт шалгалтын нэгдсэн цахим системд дэмжлэг үзүүлнэ.	-	100%	Байгууллагын зүгээс нэвтрүүлэн ашиглаж буй UB inspection, Timely зэрэг аппликейшнийг өдөр тутамын ажилд ашиглаж байна.	2025.01 2025.12	100%

1	2	3	4	5	6	7	
Зорилт-5: Хотын стандартын дагуу орчны аюулгүй байдлын хяналт, шалгалтыг сайжруулж, иргэдийн амьдрах орчны эрсдэлийг бууруулсан байна. /НХТЖҮЧ-9.5.3							
3	<u>Арга хэмжээ 1.5</u> Хотын стандартын дагуу орчны аюулгүй байдлын хяналт шалгалтыг сайжруулж, иргэдийн амьдрах орчны эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	Ус хангамж, ариутгах татуургын чиглэлээр батлагдсан хууль, норм дүрэм, үндэсний болон хотын стандартыг иргэн, аж ахуйн нэгжүүдэд сурталчлан таниулах, нэвтрүүлэх зорилгоор нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй барилга угсралтын аж ахуйн нэгж байгууллагуудад Нийслэлийн хяналт шалгалтын газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 01/1853 дугаартай батлагдсан мэдэгдэлийг хүргүүлж ажилласан.	2025.01 2025.12	100%
Зорилт-7: Үер, усны эрсдэлтэй бүсийг тогтоож, үүнд өртөж байгаа гэр хорооллын айл өрхүүдийг нүүлгэн шилжүүлж чөлөөлөх, харсний усны нэвчилттэй байшин барилгуудын суурийн хийцлэлд хүчтгэсэн хамгаалалтыг хийх, голын ай сав газрын дагуу ус зайлуулах нэгдсэн сүлжээнд холбох, шүүрүүлэх худаг байгуулах зэрэг инженерийн шугам хоолойн нэгдсэн шийдэл гаргаж иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг сайжруулна. /НЗДҮАХ-ийн 1.3.12 дахь заалт/							
4	<u>Арга хэмжээ 1.7</u> Ашиглагдаж буй барилга байгууламжийн хөрсний усны нэвчилтийн байдалд хяналт шалгалт хийж эрсдэлийг бууруулах.	Эрсдэлийг бууруулсан хувь	-	100%	Хөрсний усны тухай Улсын ахлах байцаагчийн 2025.06.24-ний өдрийн 02-13-02/041/57 дугаартай зөвлөмж 21 аж ахуй нэгж СӨХ-уудад хүргүүлэв.	2025.01 2025.12	100%
Зорилт-8: Ундны усны эх үүсвэрийн бүсийн дэглэмийг мөрдүүлж, Баруун эх үүсвэрийг ашиглалтад оруулна. /НЗДҮАХ-ийн 1.3.14 дахь заалт/							
5	<u>Арга хэмжээ 1.8</u> Улаанбаатар хотын ундны усны эх үүсвэрүүдэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, зөрчилд хариуцлага ногдуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороо Яармагын усны эх үүсвэрт холбогдсон шугам сүлжээнээс зэвтэй ус гарч байгааг шалгах ажлын хэсгээс гарсан шийдвэрийн дагуу ХУД-ийн 4,5,6,7,10,16,23,24-р хороодын цэвэр усны эх үүсвэрийн шугам сүлжээг HDPE хуванцар хоолойгоор сольж байнгын ашиглалтад хүлээн авав.	2025.01.02 2025.12.01	100%
Зорилт-10: Төрийн хяналт шалгалтын давхардлыг арилгах, хараат бус, үр дүнтэй хяналтын тогтолцоог бүрдүүлж, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. /НЗДҮАХ-ийн 5.1.7 дахь заалт/							
6	<u>Арга хэмжээ 1.10.2</u> Хяналт шалгалтын үр дүн, үр нөлөөг сайжруулах хүрээнд хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх саналыг боловсруулж,	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	100%	Урьдчилан цэвэрлэх байгууламжийн шалгалт хийх, барилга байгууламжийн ашиглалтад оруулахтай холбоотой гарын авлагад 4 заалт бүхий санлыг Нийслэлийн Засаг даргын тамгын газрын мэргэжилтэн Д.Оюунжаргалд хүргүүлэв.	2025.01.02 2025.12.01	100%

	1	2	3	4	5	6	7
	уламжлах.						
Зорилт-12: Шинэ Төв цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулж, Лаг хатаах шатаах байгууламж, шаардлага хангасан юүлэх станцын ажлыг эхэлнэ. /Нийслэлийн 2025 оны ХТ-ний 14 дахь заалт/							
7	<p><u>Арга хэмжээ 1.12</u> "Улаанбаатар хотын үйлдвэрийн хаягдал усны хяналтын чадавх бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд хаягдал устай холбоотой нэгдсэн удирлага зохицуулалтын менежментийг сайжруулах, хяналт шалгалт, зөвлөх ажлыг бохирдуулагч үйлдвэрийн ангилал бүрээр зохион байгуулж ажиллах.</p>	<p>Төслийн хэрэгжилт Нэгж байгуулах ажлын явц Хяналт шалгалт, зөвлөх ажлын явц</p>	49	49	<p>Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2025.05.13-ны өдрийн А/68 дугаартай баталсан тушаалын дагуу нийт 49 үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагаар хяналт шалгалтыг 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ. Шалгалтаар Үйлдвэрийн хэрэглээнээс гарсан бохир усыг урьдчилан цэвэрлэх байгууламжаар зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл цэвэрлээгүй, бохирдол ихтэй ус нийлүүлж буй 6 аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ авч, эрх бүхий албан тушаалтны албан даалгавар хүргүүллээ. Мөн урьдчилан цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг эрчимжүүлэх хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс бохирдол багатай болон цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа хэрэгжиж эхэлж байгаа аж ахуйн нэгжүүдэд Нийслэлийн хяналт шалгалтын газрын 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 02-13-02/041/321-358 хүртэл дугаартай Улсын ахлах байцаагчийн хугацаатай албан шаардлагыг 37 аж ахуйн нэгжид хүргүүлсэн. Нийслэлийн Засаг дарга бохирдуулагч үйлдвэрүүдийн удирдлагуудтай 2025 оны 08 дугаар сарын 19-ний өдөр уулзалт хийж урьдчилан цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулах талаар мэдэгдэл хийж, Аж ахуйн нэгж бүр Нийслэлийн Засаг даргын тамгын газар болон Ус сувгийн удирдах газартай урьдчилан цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулах хугацаатай гэрээ байгуулахыг үүрэг болгосноор албан шаардлагын биелэлтийг хангагдах ажлын нэг хэсэг болсон.</p>	<p>2025.01.02 2025.12.01</p>	100%

	1	2	3	4	5	6	7
					Мөн Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамны төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/153 дугаартай Ажлын хэсэг байгуулах тухай тушаалын дагуу гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хэрэгжүүлж ажилласан.		
Зорилт-13: Нийслэлд баригдаж байгаа барилга байгууламжийн үерийн болон борооны усыг төлөвлөлтийн дагуу зайлуулах шугам сүлжээг 5 хувиар нэмэгдүүлэн, байгууламжийг шинээр бий болгож, иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлнэ. /НХТ/							
8	Арга хэмжээ 1.13 Үер, борооны усыг хуримтлуулах, зайлуулах талаар барилга байгууламж, авто замын зураг төсөл, бүтээн байгуулалтын ажилд мөрдүүлэх хотын стандартын төсөлд санал өгч, хамтран ажиллах.	Боловсруулах хотын стандарт			Нийслэлийн удирдах ажилтнуудын 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн шуурхай зөвлөгөөн дээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас өгсөн үүрэг даалгаврын дагуу Нийслэлийн Хяналт шалгалтын газар, Хот байгуулалт, Хотын стандартын газар, Геодези усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ-аас гаргасан судалгаагаар гаргасан нийслэлийн төвийн зургаан дүүргүүдэд байрладаг хотхон хорооллуудын хур борооны ус ихээр тогтдог байршлууд болон хур борооны ус зайлуулах шугам сүлжээний угсралт, ашиглалтын төлөв байдалд Төрийн хяналт шалгалтын тухай, Барилгын тухай, Авто замын тухай хууль болон салбарын холбогдох хууль тогтоомжууд, тэдгээртэй нийцүүлэн гаргасан тогтоол, норм, дүрэм, журам, стандартуудын мөрдөлтөд хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж, Нийслэлийн хяналт шалгалтын газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 01/1853 дугаартай батлагдсан мэдэгдэлийг аж ахуйн нэгжүүдэд хүргүүлж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санлыг Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлэв.	2025.01.02 2025.12.01	100%
ХОЁР. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
Зорилт 1: Газрын үндсэн чиг үүрэгтэй холбогдох хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох.							

	1	2	3	4	5	6	7
9	<u>Арга хэмжээ 2.1.1</u> Салбарын үйл ажиллагаанд хамаарах хууль тогтоомж, хэм хэмжээний акт, норм ба дүрэм, стандартад болон холбогдох төсөлд санал хүргүүлэх.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	Урьдчилан цэвэрлэх байгууламжийн шалгалт хийх, барилга байгууламжийн ашиглалтад оруулахтай холбоотой гарын авлагад 4 заалт бүхий санлыг Нийслэлийн Засаг даргын тамгын газрын мэргэжилтэн Д.Оюунжаргалд хүргүүлэв.	2025.01.02 2025.12.01	100%
10	<u>Арга хэмжээ 2.1.2</u> Барилга, дэд бүтцийн болон бусад салбарын хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөрийг боловсруулж, дээд шатны байгууллагад уламжлах.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь			Барилга, дэд бүтцийн болон бусад хяналтын салбарын хяналт, шалгалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэгт санал өгч ажилласан.	2025.01.02 2025.12.01	100%
11	<u>Арга хэмжээ 2.1.3</u> Нийслэлийн хэмжээнд мөрдөгдөх "Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам"-ын төслийг боловсруулж, Нийслэлийн Засаг даргад өргөн мэдүүлэх.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	Нийслэлийн хэмжээнд мөрдөгдөх "Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам"-ын төслийг боловсруулж, Засаг даргад өргөн мэдүүлэхээр бэлтгэл ажлыг хангуулан ажиллаж байна.	2025.01.02 2025.12.01	100%
Зорилт 2: Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох ажиллагааг зохион байгуулна.							
12	<u>Арга хэмжээ 2.2</u> Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, зөрчлийг арилгуулах арга хэмжээг авах.	Саналын тоо	2	100%	Илэрсэн зөрчил дутагдалд 1 Зөрчлийн хэрэг нээж хянан шалгаж байна.	2025.01.02 2025.12.01	100%
Зорилт 4 Төсөв, санхүүгийн удирдлага, төлөвлөлт, гүйцэтгэл хяналт тавих, орлогын төлөвлөгөөг биелүүлж, үр дүнг тайлагнах, шилэн дансны бүртгэлийн хөтөлөлт, үнэн зөв байдлыг хангаж ажиллана							
13	<u>Арга хэмжээ 2.4</u> Зөрчлийн тухай хуулийн дагуу торгууль, шийтгэврийн орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэх.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	10 сая	Хялбаршуулсан журмаар 11 ААН байгууллага, 4 иргэнд нийт 40 сая 250 мянга төгрөгийн торгууль оногдуулж албан даалгавар өгч хэрэгжилтийг хангуулан ажиллав.	2025.01.02 2025.12.01	100%
Зорилт 6: Байгууллагын үйл ажиллагааг хүний нөөцийн удирдлагаар хангах, мэргэшсэн төрийн албан хаагчаар хангах, нөөцийн хэрэгцээг тогтоох, төлөвлөх, сургалтыг тодорхойлж хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.							
14	<u>Арга хэмжээ 2.6.1</u>	Сургалт, арга	-	1	Мэдээллийн цаг арга хэмжээний хүрээнд	2025.01.02	100%

	1	2	3	4	5	6	7
	Байгууллагын албан хаагчдад ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг солилцох, танин мэдэхүйн ач холбогдол бүхий "Мэдээллийн цаг" арга хэмжээг тогтсон хуваарийн дагуу зохион байгуулах.	хэмжээний тоо			хэлтсийн даргын баталсан хуваарийн дагуу Мянганы сорилтын сангаас хэрэгжүүлж буй төв цэвэрлэх байгууламж, Туул-1 коллекторын хэрэгжилтийн талаар мэдээлэл сургалт хийв. Мөн хэлтсийн бусад албан хаагчдын хийсэн мэдээлэлд оролцож, санап солилцов.	2025.12.01	
15	<u>Арга хэмжээ 2.6.2</u> Байгууллагын дэргэдэх зөвлөлүүдийг шинэчлэн байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх, тайлагнах.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь			Байгууллагын дэргэдэх Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаанд гишүүнээр оролцож, Хүүхдийн баярын арга хэмжээг зохион байгуулав.	2025.01.02 2025.12.01	100%
Зорилт 7: Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, стандартыг мөрдлөг болгоно.							
16	<u>Арга хэмжээ 2.7.3</u> Байгууллагын хэмжээнд иргэд, аж ахуйн нэгжээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн чанарыг сайжруулж, зөрчил үүсгэхгүй ажиллах, тайлан мэдээг хугацаанд нь гаргаж дээд шатны байгууллагад хүргүүлэх.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	Чиг үүргийн хүрээнд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын дагуу Газрын даргын баталсан 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 02-13-04/23/01 дугаартай удирдамжийн хүрээнд хяналт шалгалт хийж тайлант хугацаанд нийт 29 өргөдөл гомдол ирсэнээс 19 шийдвэрлэсэн 101 албан бичиг ирснээс 98 буюу 95 хувийг шийдвэрлэж, холбогдох мэдээ тайланг Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнд тухай бүрт хүргүүлэв.	2025.01.02 2025.12.01	100%
Зорилт 8: Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх.							
17	<u>Арга хэмжээ 2.8.2</u> Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан нийтлэг хэм хэмжээ, ёс зүйн шаардлага, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан "Ёс зүйн хэм хэмжээ"-г мөрдлөг болгох.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	Байгууллагын ёс зүйн дэд хорооноос Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөх тухай зөвлөмжийг хүлээн авч ажилдаа мөрдлөг болгон ажиллаж байна.	2025.01.02 2025.12.01	100%

	1	2	3	4	5	6	7
Зорилт 9 : Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.							
18	<u>Арга хэмжээ 2.9.2</u> Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийг мөрдлөг болгон ажиллах.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллаж хэвшсэн.	2025.01.02 2025.12.01	100%
Зорилт 10: Зорилтот жилийн хүрээнд барилга, дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажилд хяналт тавих, иргэдийн амьдрах орчныг сайжруулах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.							
19	<u>Арга хэмжээ 2.10</u> Нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих, нийслэлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг чиг үүргийн хүрээнд хангуулах, тайлагнаж ажиллах.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай" 62, 223 дугаар тогтоолын хэрэгжилт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2025 оны "Агаар бохирдуулагч эх үүсвэрийн судалгаа гаргах, хяналт шалгалт зохион байгуулах тухай" А/33 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогчийн баталсан удирдамж, нийслэлийн Хяналт шалгалтын газрын даргын баталсан 02-13-01/025/09 дугаартай удирдамжийн дагуу усан халаалтын 3-15кВт хүртэл, 15-100кВт хүртэл хүчин чадалтай халаалтын зуухны дэлгэрэнгүй мэдээллийн судалгаа болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын халаалтын зуухны ашиглалтын байдал, түүхий нүүрс ашиглах тусгай зөвшөөрөлтэй эсэх, гэр хорооллын айл өрхийн пийшин, зуухны галлагааны аюулгүй байдал, угаарын хий мэдрэгч төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, агаар бохирдуулагч гуравдагч эх үүсвэр түлж байгаа эсэхэд хамтарсан хяналт шалгалт хийлээ. Шалгалтаар 2025 оны 01 дүгээр сарын 18, 19-ний өдөр Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрийн айл өрх болон ААН-үүдэд хяналт шалгалт судалгааны ажил хийж гүйцэтгэлээ.	2025.01.02 2025.09.01	100%
ГУРАВ. ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							

	1	2	3	4	5	6	7
Зорилт 1: Барилга, дэд бүтцийн салбарын Барилга байгууламжийн техникийн хяналтын чиглэлээр эрсдэлийн үнэлгээгээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектуудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийнэ. /Газрын дүрмийн- 4.2, 4.3, 4.5.3/							
20	Арга хэмжээ 3.1 Барилга байгууламжийн техникийн хяналтын чиглэлээр төрийн хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх	Төлөвлөгөөт шалгалт хийсэн объектын тоо	10	10	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 02-00/04 дугаартай төлөвлөгөөт шалгалт хийх тухай удирдамжийн хүрээнд 10 аж ахуйн нэгж байгууллагад хяналт шалгалт хийхээр төлөвлөж 10 ААНБ-д хяналт шалгалт хийлээ. Үүнд: Ус хангамж ариутгах татуургын чиглэлийн шалгах 02.4.4, 02.4.3 дугаар бүхий хяналтын хуудсуудын дагуу төлөвлөгөөт хяналт шалгалт хийж шалгалтад дунд эрсдэлтэй гарсан 2 ААНБ-д улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлэн ажилласан бөгөөд бага эрсдэлтэй гарсан 7 ААНБ-дад хууль, стандарт, норм дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар 02-13-01/041/39 дугаартай Улсын ахлах байцаагчийн зөвлөмжийг тус тус хүргүүлэн ажиллалаа. Мөн 1 аж ахуйн нэгж байгуулга 2025 онд үйл ажиллагаа явуулаагүй талаар	2025.01.02 2025.09.01	100%
20	Арга хэмжээ 3.1 Барилга байгууламжийн техникийн хяналтын чиглэлээр төрийн хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх.	Урьдчилан сэргийлэх шалгалт хийсэн объектын тоо;	30	15	- Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2025.05.23-ны өдрийн А/68 дугаартай баталсан тушаалын дагуу нийт 49 үйлдвэр, аж ахун нэгж байгууллагуудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж зөрчил илэрсэн 6 аж ахуйн нэгж байгууллагад хялбаршуулсан журмаар нийт 12.0 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөрчил арилгуулах тухай ЭБАТ-ны албан даалгавар хүргүүлж, нийслэлийн Прокурорын газрын хяналтын Прокурорт хянуулж ажилласан. - Нийслэлийн засаг даргын 2025 оны А/214 дугаартай захирамжаар нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй нийтийн байрны орчин, нөхцөл байдалд Нийслэлийн	2025.01.02 2025.12.01	100%

	1	2	3	4	5	6	7
					Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогчоор ахлуулсан Баянгол дүүрэгт 186 нийтийн байраар 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрөөс 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн хооронд ажилласан. Хяналт шалгалтаар нийтийн байрны үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн орчин сул, төрийн захиргааны байгууллагад бүртгэлгүй, төрийн зохицуулалт, хараа хяналтаас орхигдсон тул байр, үйлчилгээнд тавигдах стандарт шаардлага байхгүй, нэг хүний амьдрах орчны стандарт зөрчигдсөн, байгууламж шатах эрсдэлтэй болон орчны аюулгүй байдал алдагдсан зэрэг нийтлэг нийт 96 зөрчил илрүүлж, 45 зөвлөмж, 42 мэдэгдэл, 4 албан шаардлагыг тус тус хүргүүлэн ажилласан байна.		
20	Арга хэмжээ 3.1 Барилга байгууламжийн техникийн хяналтын чиглэлээр төрийн хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх.	Төлөвлөгөөт бус шалгалт хийсэн объектын тоо;	100	-	Чиг үүргийн хүрээнд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын дагуу Газрын даргын баталсан 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 02-13-04/23/01 дугаартай удирдамжийн хүрээнд хяналт шалгалт хийж тайлант хугацаанд нийт 114 өргөдөл гомдол ирсэнээс 114 шийдвэрлэсэн 192 албан бичиг ирсэнээс 192 буюу 100 хувийг шийдвэрлэн илэрсэн зөрчил дутагдалд 53 ААН-д албан шаардлага хүргүүлэн, 11 ААН 37 сая, 6 иргэн 3,200 мянга нийт 40,250 сая төгрөгийн торгууль ноогдуулж, ажиллаад байна.	2025.01.02 2025.12.01	100%
		Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь, - Зөрчил арилгалт хувь	15	-		2025.01.02 2025.12.01	100%
Зорилт 2: Салбарын хууль тогтоомж, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрахад чиглэсэн хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.							
21	Арга хэмжээ 3.2.1 Удирдах байгууллага, албан тушаалтнаас өгөгдсөн цаг үеийн асуудлаар өгсөн үүрэг даалгаврын дагуу хяналт	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	Хүннү 2222 хотхоны зам дагуух Суруга монгол ХХК-ийн ашиглалтад оруулсан авто замын борооны ус зайлуула шугам сүлжээний ашиглалтын төлөв байдал хяналт шалгалт хийж, Улсын ахлах байцаагчийн албан шаардлага	2025.01.02 2025.12.01	100%

	1	2	3	4	5	6	7
	шалгалтын ажлыг зохион байгуулах, үр дүнг тайлагнах.				хүргүүлэв.		
22	<u>Арга хэмжээ 3.2.2</u> Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээллийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийх.	Өргөдөл гомдлын шийдвэрлэлт /хувь/ Зөрчил арилгалт /хувь/	-	100%	Ус хангамж, ариутгах татуурга чиглэлийн хүрээнд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын дагуу Газрын даргын баталсан 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 02-13-04/23/01 дугаартай удирдамжийн хүрээнд хяналт шалгалт хийж тайлант хугацаанд нийт 117 өргөдөл гомдол ирсэнээс 115 шийдвэрлэсэн 131 албан бичиг ирснээс 128 буюу 98 хувийг шийдвэрлэн ажиллаад байна.	2025.01 2025.12	100%
Зорилт 3: Хууль тогтоомж, стандарт, норм, дүрмийн мөрдүүлэхэд төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг мэдээлэл, сургалт, арга зүйгээр хангах, зөвлөн туслах, сурталчлан таниулна. /Газрын дүрмийн-4.5.1/							
23	<u>Арга хэмжээ 3.3.2</u> Барилгын угсралт, ашиглалт болон дэд бүтцийн салбарт хууль, стандарт, нормыг мөрдүүлэх чиглэлээр иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад зөвлөн туслах, сургалт зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/01 дүгээр захирамжаар 2025 оныг "Бүтээн байгуулалтын жил" болгон зарласантай холбогдуулан барилга байгууламжийн ашиглалтыг сайжруулах, орчны аюулгүй байдлыг хангуулах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор дүүргүүдийн орчны эрүүл аюулгүй байдал, тохижилтод стандарт хангуулах, барилга байгууламжийн ашиглалтыг хариуцагч иргэн, аж ахуйн нэгж, сууц өмчлөгчдийн холбоод, төрийн албан хаагч нарт сургалт зохион байгуулахаар төлөвлөж Газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01/86 дугаартай "Сургалт зохион байгуулах тухай" албан бичгийн дагуу нийслэлийн төвийн 6 дүүргийн Засаг даргын Тамгын газрын тохижилт нийтийн аж ахуйн хэлтсүүдтэй хамтран батлагдсан хуваарийн дагуу 2 дугаар сарын 18-аас 21-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулсан.	2025.01 2025.12	100%

	1	2	3	4	5	6	7
24	<u>Арга хэмжээ 3.3.3</u> Хяналт шалгалтын дүнгийн талаар хяналтын чиглэл бүрээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл, сэрэмжлүүлэг, зөвлөмж өгөх.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	дүүрэг-200 гаруй, Сонгинохайрхан Сүхбаатар дүүргийн 10 дугаар хороо Нийслэлийн орон сууцны корпораци ХК захиалгатай үйлчилгээтэй орон сууцны барилгын ажил гүйцэтгэж байгаа Мөнх ариун булаг ХХК-ийн хашаан дотор 24 дүгээр болон цэцэрлэг 43 дугаар байрны ариутгах татуургын дундын эзэмшлийн шугам сүлжээний бохир усны 3 дугаар худаг дарагдаж 1,2 дугаар худаг бохир усаар дүүрч, цэцэрлэгийн барилгад бохир халисан байгаа болон барилга угсралтын ажилд бүрэлдхүүнтэй хяналт шалгалт хийж Нийслэлийн хэвлэл мэдээлэлд холбогдох мэдээллийг өгч ажиллаа.	2025.01 2025.12	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрсэн түвшин (биелэлт)				
			Суурь түвшин	Эхний хагас жил	Сүүлийн хагас жил	Эхлэх хугацаа	Биелэлтийн хувь
"ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.	Нийслэлийн хүний нөөцийн хөгжлийн төв, холбогдох төрийн байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдах.	Мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна.	-	100%	- Улаанбаатар хотын орон сууцны эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх төслийн хүрээнд "Барилгын эрчим хүчний хэмнэлтийн үр ашиг" сэдвээр 32 цагийн сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан. -Мөн үйлдвэрийн автоматжуулалт сургалтад цахимаар суралцаж нийт 5 удаагийн цахим сургалтыг үзэж танилцаад байна. 2.Барилгын салбарын мэргэжилтнүүдийн мэргэжил дээшлүүлэх зэргийн багц цаг тооцох 4 багц заавал сургалтад 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрөөс 29-ний өдрүүдэд хамрагдаж гэрчилгээ авсан. 3.Монголын барилгын инженерүүдийн холбооноос зохион байгуулсан Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах	2025.01 2025.12	100%

					<p>эрхийг хангах, зорилтын хүрээнд хот байгуулалт, дэд бүтцийн салбарт хэрэгжих бүтэн байгуулалт, ашиглалт засварын ажил, үйлчилгээнд хууль, тогтоомж, үндэсний болон хотын стандарт, нормыг мөрдүүлэх, төрийн хяналт шалгалтын үр нөлөөтэй байдлыг сайжруулах сэдэвт 2 багц гэрчилгээ олгох сургалтад хамрагдав.</p> <p>-Удирдлагын академийн Төрийн захиргааны ахлах түшмэлийн мэргэшүүлэх 8 долоо хонгийн багц сургалтад хамрагдаж байна.</p>		
--	--	--	--	--	--	--	--

Handwritten signature
21/09

ТАЙЛАН ГАРГАСАН:

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ТЕХНИКИЙН
ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ
БАЙЦААГЧ

(Албан тушаал)

Handwritten signature of B. Temүүлэн

/Б.ТЭМҮҮЛЭН /

(Нэр, гарын үсэг)

(Огноо)

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

ДБСХХ-ИЙН ДАРГА

(Албан тушаал)

Handwritten signature of G. Batbatar

/Г.БАТБААТАР /

(Нэр, гарын үсэг)

(Огноо)

ДЭД БҮТЦИЙН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ
ЗАГДСҮРЭН ОВОГТОЙ ОЧИРПҮРЭВИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1.Хяналт шалгалтын цахим системийг нэвтрүүлж, шаардлагатай мэдээллийн хүртээмж, ил тод байдлыг хангана. /МУЗГҮАХ-4.1.4.1, НЗДҮАХ-5.1.8/							
1.	Арга хэмжээ 1.1. Дэд бүтцийн салбарын хяналтын нэгдсэн цахим системийг хөгжүүлэх үйл ажиллагаанд ашиглах	Хяналт шалгалтын нэгдсэн цахим систем буюу application хөгжүүлэлт, хувь	-	100%	1.Дэд бүтцийн чиглэлээр ажил үйлчилгээ эрхэлдэг 250 аж ахуйн нэгж, байгууллагын эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлийн үнэлгээг http://shilenkhyanal.gov.mn системд оруулав. Эрчим хүчний хяналтын чиглэлээр 10 объектод төлөвлөгөөт хяналт шалгалтыг бүртгэлжүүлэн хяналтын хуудсыг бөглөн баталгаажуулсан. 2.Хяналт шалгалтын нэгдсэн цахим систем буюу application-г татаж утсандаа суулган төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг бүртгэлжүүлэн ажиллаж байна.	2025.01-2025.12	100%
Зорилт 2. Хотын стандартын дагуу орчны аюулгүй байдлын хяналт, шалгалтыг сайжруулж, иргэдийн амьдрах орчны эрсдэлийг бууруулсан байна. /НХТЖҮЧ-9.5.3/							
2.	Арга хэмжээ 2.1. Хотын стандартын дагуу орчны аюулгүй байдлын хяналт шалгалтыг сайжруулж, иргэдийн	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	1.Нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллах, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх	2025.01-2025.12	100%

	1	2	3	4	5	6	7
	амьдрах орчны эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх.				<p>зорилгоор нийтийн эзэмшлийн гудамж талбайд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандартын зөрчлийг газар дээр нь шуурхай арилгуулах, шаардлагатай тохиолдолд зөрчил гаргасан иргэн, аж ахуйн нэгжид хуулийн хүрээнд арга хэмжээ авч зөрчлийг арилгах, хашаа хайсыг албадан буулгах, газрыг чөлөөлөх, зөвшөөрөлгүй болон хууль, тогтоомж, барилгын норм ба дүрмийг зөрчиж барьсан барилга, байгууламжийг албадан буулгах, эрсдэл учруулж буй эд зүйл, техник хэрэгслийг шилжүүлж зам талбайг чөлөөлөх, хотын стандартыг мөрдүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/237 дугаар захирамжийн дагуу Сүхбаатар дүүрэгт 2, 3 дугаар ажлын хэсэгт орж ажиллан 40 аж ахуйн нэгж иргэний барилга, байгууламжид хяналт хийж 30 зөрчил илрүүлж 10 шаардах хуудас, ХББОСЯ-ны 2025/01 албан даалгаврыг 20 иргэн аж ахуйн нэгжид хүргүүлэн ажилласан.</p> <p>2.НЗД-ын баталсан "Ажлын хэсэг байгуулах тухай" А/214 дугаартай захирамж болон газрын даргын баталсан "Нийтийн байрны барилга, байгууламжид урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай" 02-13-04/23/12 дугаартай удирдамжийн дагуу нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгт байрлах 40 гаруй нийтийн байранд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хяналт шалгалт хийв.</p>		
<p>Зорилт 3.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд тэгш, хүртээмжтэй оролцох боломжийг нэмэгдүүлж, барилга байгууламж, явган хүний зам, гэрлэн дохиог олон улсын стандартад нийцүүлэн өөрчилнө. /НЗДҮАХ 2.3.2, НХТЖҮЧ-9.5.1/</p>							

	1	2	3	4	5	6	7
3.	Арга хэмжээ 3.1. Төрийн болон нийгмийн үйлчилгээний барилгыг хүртээмжтэй дэд бүтцийн стандартад нийцүүлж, ашиглалтад оруулах.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	Эрчим хүчний барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах 120 орчим улсын комиссын бүрэлдэхүүнд гишүүнээр орж ажиллан давтагдсан тоогоор 960 орчим үүрэг даалгавар өгч, үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах санал өгч ажилласан.	2025.01-2025.12	100%
Зорилт 4.Төрийн хяналт шалгалтын давхардлыг арилгах, хараат бус, үр дүнтэй хяналтын тогтолцоог бүрдүүлж, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. /НЗДҮАХ 5.1.7/							
4.	Арга хэмжээ 4.1. Төрийн хяналт шалгалтын эрх зүйн орчныг ижил түвшний эрх зүйн тогтолцоо бүхий улс орны хяналтын тогтолцоонд хийсэн судалгаатай танилцаж, санал боловсруулж хүргүүлэх.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 03 дугаартай тогтоолын хүрээнд Дэд ажлын хэсэг байгуулж, барилга дэд бүтцийн хяналтын салбарт дүн шинжилгээ хийж, холбогдох саналыг боловсруулах, цаашид авах арга хэмжээний талаарх саналд гадны орны буюу Канад, Орос, Африк, Азийн орнуудын туршлагыг судлан хиймэл оюун ухаан болон холбогдох эх сурвалжаас боловсруулан нэгтгэж Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 01/339 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.	2025.01-2025.12	100%
5.	Арга хэмжээ 4.2. Төрийн хяналт шалгалтын хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх саналыг боловсруулж, уламжлах.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	1.Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1759 дүгээр захирамжаар ажлын хэсгийг байгуулж Төрийн хяналт шалгалтын эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор төрийн хяналт шалгалтын тогтолцоо, хяналт шалгалт хийх нийтлэг журмыг боловсруулан хяналт хэрэгжүүлэх 5 байгууллагын 19 санал, тус газрын БСАБХХ болон ДБСХХ-ийн нийт давхартсан тоогоор шинээр нэмэх 7, хасах 7, утга найруулга засах 40	2025.01-2025.12	100%

	1	2	3	4	5	6	7
					<p>саналыг нэгтгэж ажлын хэсгийн бүрэлдэхүүн нь 2025 оны 02 дугаар сарын 10 өдрийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулсан.</p> <p>2.Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 03 дугаартай тогтоолоор Нийслэлийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох, судалгаа шинжилгээ хийх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн анхдугаар хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу чиг үүргийн судалгаа шинжилгээ хийх, санал боловсруулах үүрэгтэй Дэд ажлын хэсэг байгуулж, барилга дэд бүтцийн хяналтын салбарт дүн шинжилгээ хийж, холбогдох саналыг боловсруулж, цаашид авах арга хэмжээний талаарх саналыг нэгтгэж Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 01/339 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.</p>		
Зорилт 5.Хяналтын чиг үүргийн байгууллагын харьяанд туршилт шинжилгээний дэвшилтэт технологи бүхий итгэмжлэгдсэн лабораторийг өргөжүүлж, чадамжийг дээшлүүлнэ. /НЗДҮАХ 5.1.9/							
6.	<p>Арга хэмжээ 5.1.Автозамын материал, хийц, бүтээц, эзлэхүүний шинж чанарыг тодорхойлох, газрын тос, хийн үзүүлэлтийг хэмжих, сорилт шинжилгээний лаборатори байгуулах бэлтгэл ажлыг хангуулах.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>	-		<p>Барилга, дэд бүтцийн 13 чиглэлээр Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай</p>	2025.01-2025.12	100%

	1	2	3	4	5	6	7
					<p>хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, салбарын болон холбогдох бусад хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулан ажиллахад стандартын шаардлага хангаагүй бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлдвэрлэлд хэрэглэх, худалдан борлуулах зэрэг зөрчил илэрсээр байгаа нь хүний эрүүл мэнд, улмаар улс орны аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх, цаашид барилгад хэрэглэгдэх шинэ материал, технологийн хөгжилтэй уялдуулан орчин үед нийцсэн сорилт шинжилгээний лабораторийг шинээр байгуулан шинжилгээний үр дүнг үнэн зөв, өндөр магадлалтай тогтоон тодорхойлох шаардлагатай байгааг үндэслэн нийслэлийн сорилт шинжилгээний лабораторийг байгуулах саналыг нэгтгэж НЗДТГ-т 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01/84 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.</p>		
Зорилт 6.Газрын үндсэн чиг үүргийн хүрээнд хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад уламжилна.							
7.	<p>Арга хэмжээ 6.1. Дэд бүтцийн салбарын үйл ажиллагаанд хамаарах хууль тогтоомж, хэм хэмжээний акт, норм ба дүрэм, журам, стандартад болон холбогдох төсөлд санал хүргүүлэх.</p>	<p>Үйл ажиллагааний хэрэгжилт, хувь</p>	1	100%	<p>1.Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 80 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгээс боловсруулсан Дулаан хангамжийн тухай хуулийн төсөлд 14 саналыг Нийслэлийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 06/463 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>2.Хяналт, удирдлагын нэгдсэн цахим системийн shilenhyanalт.gov.mn сайтын шинэчлэл сайжруулалттай холбоотой 4 саналын Цахим хөгжил, инноваци</p>	2025.01-2025.12	100%

	1	2	3	4	5	6	7
					харилцаа холбооны яамд хүргүүлэн ажилласан.		
8.	Арга хэмжээ 6.2. Дэд бүтцийн болон бусад салбарын хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах талаар боловсруулсан хөтөлбөртэй танилцаж, санал боловсруулж, дээд шатны байгууллагад уламжлах.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь			Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 03 дугаартай тогтоолоор Нийслэлийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох, судалгаа шинжилгээ хийх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн анхдугаар хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу чиг үүргийн судалгаа шинжилгээ хийх, санал боловсруулах үүрэгтэй Дэд ажлын хэсэг байгуулж, барилга дэд бүтцийн хяналтын салбарт дүн шинжилгээ хийж, холбогдох саналыг боловсруулж, цаашид авах арга хэмжээний талаарх саналыг нэгтгэж Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 01/339 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.	2025.01-2025.12	100%
9.	Арга хэмжээ 6.3. Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр дотоод дүрэм, журмыг боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах.	Дүрэм, журмын тоо	-	100%	Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр газрын шинэчлэн батлах хөдөлмөрийн дотоод журамд нийт 6 саналыг Захиргаа, санхүүгийн хэлтэс хүргүүлсэн.	2025.01-2025.12	100%
10.	Арга хэмжээ 6.4. Хариуцсан чиг үүргийн хүрээнд Нийслэлийн Засаг даргыг шүүхэд итгэмжлэлээр төлөөлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу оролцох, үр дагаврыг Нийслэлийн Засаг даргын өмнө бүрэн хариуцах.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	Одоогоор шүүхэд итгэмжлэлээр төлөөлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоогүй болно.	2025.01-2025.12	100%
Зорилт 7. Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох ажиллагааг зохион байгуулна.							

	1	2	3	4	5	6	7
11.	Арга хэмжээ 7.1. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, зөрчлийг арилгуулах арга хэмжээг авах.	Зөрчил арилгуулалтын хувь	1	100%	Тайлант хугацаанд эрчим хүчний хяналтын чиглэлээр 1 хэрэгт зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж 3.0 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.	2025.01-2025.12	100%
Зорилт 8.Эрчим хүчний тухай хуулийн дагуу хянан баталгаажуулах үйл ажиллагааг явуулна.							
12.	Арга хэмжээ 8.1. Зуух, даралтат сав, шугам хоолойн техникийн магадлал, баталгаажуулалт хийж, бүртгэлд хамруулах.	Баталгаажуулахад хамрагдсан зуух, даралтат сав шугам хоолой	-	100%	Эрчим хүчний хяналтын чиглэлээр 2025 оны жилийн байдлаар 100 кВт-аас дээш хүчин чадалтай усан халаалтын зууханд нийт 6 паспорт олгоод байна.	2025.01-2025.12	100%
Зорилт 9.Төсөв, санхүүгийн удирдлага, төлөвлөлт, гүйцэтгэл хяналт тавих, орлогын төлөвлөгөөг биелүүлж, үр дүнг тайлагнах, шилэн дансны бүртгэлийн хөтлөлт, үнэн зөв байдлыг хангаж ажиллана.							
13.	Арга хэмжээ 9.1. Зөрчлийн тухай хуулийн дагуу торгууль, шийтгэврийн орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэх	Хүү торгуулийн орлого, сая төгрөг	5,0 сая	100%	Тайлант хугацаанд эрчим хүчний хяналтын (дулаан хангамж) чиглэлээр 1 хэрэгт зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, 3.0 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.	2025.01-2025.12	100%
Зорилт 11.Байгууллагын үйл ажиллагааг хүний нөөцийн удирдлагаар хангах, мэргэшсэн төрийн албан хаагчаар хангах, нөөцийн хэрэгцээг тогтоох, төлөвлөх, сургалтыг тодорхойлж хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.							
14.	Арга хэмжээ 11.1. Байгууллагын болон хэлтсийн албан хаагчдад ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг солилцох, танин мэдэхүйн ач холбогдол бүхий "Мэдээллийн цаг" арга хэмжээг тогтоосон хуваарийн дагуу зохион байгуулах.	Сургалт, арга хэмжээний тоо	-	1	Байгууллагын болон хэлтсээс албан хаагчдад ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг солилцох, танин мэдэхүйн ач холбогдол бүхий "Мэдээллийн цаг" арга хэмжээнд нийт 6 удаа хамрагдсан.	2025.01-2025.12	100%
Зорилт 12.Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, Засгийн газрын сайдуудтай хийх гэрээ, Нийслэлийн Засаг даргын шийдвэр, газрын даргын үүрэг даалгаврын биелэлтийг нэгтгэн тайлагнах, хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийнэ.							
15.	Арга хэмжээ 12.1. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх асуудлын талаар танилцуулга, мэдээ тайлан бичих, хуралдааны тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, тайлагнах.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүр биелэлтийг гарган, хэлтсийн ахлах, даргаар баталгаажуулан Захиргаа, санхүүгийн хэлтэст хүргүүлэн ажилласан.	2025.01-2025.12	100%

	1	2	3	4	5	6	7
Зорилт 13. Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, стандартыг мөрдлөг болгоно.							
16.	Арга хэмжээ 13.1. Дэд бүтцийн хяналтын чиглэлээр хийгдсэн хяналт шалгалтын холбогдох материалуудыг эмхэтгэн архивлах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	Эрчим хүчний хяналтын чиглэлээр хийгдсэн дотоод ажлыг 2 боть архив үүсгэн хадгалсан.	2025.01-2025.12	100%
17.	Арга хэмжээ 13.2. Дэд бүтцийн хяналтын чиглэлээр иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн албан бичиг, хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх, зөрчил үүсгэхгүй ажиллах.	Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, хувь	-	100%	Тайлант хугацаанд 59 өргөдөл гомдол, 68 албан бичиг ирснээс хуулийн хугацаанд нь 59 өргөдөл гомдлыг шийдвэрлэж, 67 албан бичгийн шийдвэрлэн ажилласан.	2025.01-2025.12	100%
Зорилт 14. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.							
18.	Арга хэмжээ 14.1. ХАСХОМ (Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг)-ийг хуулийн хугацаанд мэдүүлэх.	-	-	100%	ХАСХОМ-ыг 2024.02.05-ны дотор хуулийн хугацаанд бүрэн баталгаажуулж илгээсэн.	2025.01-2025.12	100%
19.	Арга хэмжээ 14.2. Дутагдлыг арилгуулахаар өгсөн албан шаардлага, албан даалгаврын биелэлтийг хангуулахаар гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх. (ГТТ-ний 4.3.3)	-	Албан хаагчдын тоо		Тайлант хугацаанд Улсын (ахлах) байцаагчийн 34 заалт бүхий 11 албан шаардлага, 1 албан даалгавар иргэн аж ахуй нэгжид хүргүүлэн биелэлтэд хяналт тавин ажилласан.	2025.01-2025.12	100%
Зорилт 15. Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомж, хэм хэмжээг мөрдлөг болгох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.							
20.	Арга хэмжээ 15.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан нийтлэг хэм хэмжээ, ёс зүйн шаардлага, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан "Ёс зүйн хэм хэмжээ"-г мөрдлөг болгож ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	Байгууллагын Ёс зүйн дэд хорооноос Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хууль, Төрийн захиргааны албан тушаалтны ёс зүйн хэм хэмжээг зохицуулсан ЗГ-ын 109 дүгээр тогтоолын зүйл заалтыг танилцуулах тараах материалтай танилцаж мөрдлөг болгон ажиллаж байна.	2025.01-2025.12	100%
Зорилт 16. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.							
21.	Арга хэмжээ 16.1. Дэд бүтцийн салбарын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, салбарын оролцогчдыг соён гэгээрүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	Улсын ерөнхий прокурорын газар болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас хамтран зөрчил шалган шийдвэрлэх, хяналт тавих	2025.01-2025.12	100%

	1	2	3	4	5	6	7
	чиглэлээр иргэн, хуулийн этгээдэд чиглэсэн сургалт зохион байгуулах.				байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, харилцан мэдээлэл солилцох Зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилготой "Зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан"-г хэрэглээнд нэвтрүүлэх сургалтад 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр хамрагдсан.		
22.	Арга хэмжээ 16.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийг мөрдлөг болгон ажиллах.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	Улсын ерөнхий прокурорын газар болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас хамтран зөрчил шалган шийдвэрлэх, хяналт тавих байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, харилцан мэдээлэл солилцох Зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилготой "Зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан"-г хэрэглээнд нэвтрүүлэх сургалтад 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр хамрагдсан.	2025.01-2025.12	100%
Зорилт 17.Зорилтот жилийн хүрээнд барилга, дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажилд хяналт тавих, иргэдийн амьдрах орчныг сайжруулах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.							
23.	Арга хэмжээ 17.1. Нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнаж ажиллах.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	1.Газрын даргын өргөтгөсөн шуурхай хурал дээр агаарын бохирдлыг бууруулах, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээтэй холбоотой томоохон хэрэгжүүлж буй 14 мега төслийн хэрэгжилтийн явцтай танилцсан.	2025.01-2025.12	100%
Зорилт 18.Засгийн газрын сайдуудтай хийх гэрээ, Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, Нийслэлийн Засаг даргын шийдвэр, газрын үндсэн чиг үүргийн биелэлтийг нэгтгэх, тайлагнах, хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх.							
24.	Арга хэмжээ 18.1. Эрчим хүч, Зам, тээврийн, Аж үйлдвэр, эрдэс баялагийн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд нар, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай байгуулсан хамтран ажиллах гэрээний	Биелэлт хүргүүлэх тоо	2	1	Эрчим хүчний сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай хамтарсан гэрээний биелэлтийг 1 дүгээр улирлын байдлаар гарган Захиргаа, санхүүгийн хэлтэст хүргүүлсэн.Мөн 2025 оны эхний хагас жилийн гэрээний биелэлтийг хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	2025.01-2025.12	100%

	1	2	3	4	5	6	7
	биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж хүргүүлэх. (ГГТ-ний 7.1)						
Зорилт 19. Дэд бүтцийн салбарын хяналтын чиглэлээр эрсдэлийн үнэлгээгээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектуудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийнэ.							
25.	Арга хэмжээ 19.1. Эрчим хүчний хяналтын чиглэлээр (дулаан): Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, шинээр ашиглалтад орж буй барилгын гадна дулааны шугам сүлжээний зураг төсөл, угсралтын байдалд хяналт шалгалт хийх.	Төсөл арга хэмжээний тоо	3	-	1.Эрчим хүчний сайдын 2025 оны 01-р сарын 07-ны өдрийн А/05 дугаартай тушаал, салбарын ерөнхий байцаагчийн баталсан 11/03 дугаартай удирдамжийн дагуу шинээр ашиглалтад орж буй барилгын гадна дулааны шугам сүлжээний зураг төсөл, угсралтын байдалд нийт 10 аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар 1 зөрчлийн хэрэг нээн хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулсан. Мөн 5 аж ахуйн нэгж байгууллагад улсын (ахлах) байцаагчийн 14 заалт бүхий албан шаардлагын хүргүүлсэн. Тус шалгалтын танилцуулгыг бэлтгэн 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр газрын даргад танилцуулан баталгаажуулсан болно. 2.Эрчим хүчний сайдын 2025 оны 01-р сарын 07-ны өдрийн А/05 дугаартай тушаал, салбарын ерөнхий байцаагчийн баталсан 11/03 дугаартай удирдамжийн дагуу ДЦС-4 ТӨХК-д Эрчим хүчний яамны холбогдох албан тушаалтан нартай хамтран төлөвлөгөөт хяналт шалгалт хийж улсын ахлах байцаагчийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 11-00-01/014/07 дугаартай албан шаардлагыг хүргүүлэн ажилласан	2025.01-2025.12	100%
Зорилт 20.Барилга, дэд бүтцийн салбарын хяналтын чиглэлээр болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөрчил, дутагдал, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох зорилгоор урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийнэ.							
26.	Арга хэмжээ 20.1. Эрчим хүчний хяналтаар (дулаан): 100 кВт-аас дээш хүчин чадалтай уурын болон усан	Төсөл арга хэмжээний тоо	-	-	1.Газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн "Уурын болон усан халаалтын зуухны техник ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрмийн	2025.01-2025.12	100%

	1	2	3	4	5	6	7
	халаалтын зуухны ашиглалтын төлөв байдалд хяналт шалгалт хийх.				<p>хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” 02-13-04/023/27 дугаартай удирдамжийг батлуулан 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдрүүдэд Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороо, 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 100 кВт-аас дээш хүчин чадалтай 10 аж ахуйн нэгж, байгууллагын 13 уурын болон усан халаалтын зуухнуудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж 3 аж ахуйн нэгж байгууллагад улсын байцаагчийн 7 заалт бүхий албан шаардлагыг хүргүүлэв. Мөн тус хяналт шалгалтын танилцуулгыг бичиж газрын даргад 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдөр танилцуулан ажилласан болно.</p> <p>2.Эрчим хүчний яам, Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025.01.23-ны өдрийн 11/04 дугаартай урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай баталсан удирдамжийн дагуу ХУД-ийн 15-р хороо Цэнгэлдэх ОСНААК ХХК, Баатардулаан хан ХХК-ийн эзэмшлийн УДДТ болон дулаан хангамжийн ашиглалтын төлөв байдал, холбогдох бичиг баримтад үзлэг шалгалт хийн ажиллаж улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэн ажилласан.</p> <p>3.Мөн Улаанбаатар Дулааны сүлжээ ТӨХК-ны эзэмшлийн дулаан хангамжийн ашиглалтын төлөв байдал, холбогдох бичиг баримтад урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэн улсын байцаагчийн хугацаатай албан шаардлагыг хүргүүлэн ажилласан.</p>		

	1	2	3	4	5	6	7
Зорилт 21.Салбарын хууль тогтоомж, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрахад чиглэсэн хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.							
